



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ДАДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 29 өдөр

Дугаар М/У

Дадал сум

**Засаг даргын нөөц сангаас зардал
гаргах тухай**


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралт “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.5, 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол үндэсний бахархал болсон босоо бичгээ нийтэд сурталчлах, суралцагчдын авьяас чадвар сонирхлыг дэмжиж, үндэсний бичиг, өв соёлоо түгээн дэлгэрүүлэх “Уран бичгийн өв тээгч” уралдаанд оролцогчид болон сумын Онон, Агац, Балж, Баян-Овоо багуудын нийт иргэдийн идэвхийг нэмэгдүүлэх, төр засгийн бодлого шийдвэр, шинээр хэрэгжиж буй хууль дүрмийг сурталчлан танилцуулж, иргэдэд тулгамдаж буй асуудлыг сонсож шийдвэрлэх, мэдээ мэдээлэл хүргэх, төрийн үйлчилгээг газар дээр нь хүргэх үйл ажиллагааны шатахууны зардал гаргасугай.

2. Зардлын 1,444,000 (Нэг сая дөрвөн зуун дөчин дөрвөн мянга) төгрөгийг Засаг даргын нөөц сангаас гарган зарцуулахыг нягтлан бодогч (Д.Энхзул)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн албаны дарга (Д.Агаармандал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.МӨНХХУЯГ

010000223